

  
МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 188


Улаанбаатар хот

Г

“Дархлаажуулалтын 10 хоног”-ийг  
зохион байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Дархлаажуулалтын тухай хуулийн 11.1, Дархлаажуулалтын зөвлөх хорооны 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Хүүхэд бүрийг улаанбурхан өвчний эсрэг вакцинд бүрэн хамруулья” уриан дор 05 дугаар сарын 15-наас 25-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Улаанбурхан өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар, нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг туривдугаар, улаанбурхан өвчний эсрэг вакцин, дагалдах хэрэгслэлийн хуваарийг дөрөвдүгээр, улаанбурхан өвчний эсрэг вакцины хэрэглэх зааврыг тавдугаар, мэдээлэл, сурталчилгааны материалын хуваарийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Улаанбурхан өвчний нэмэлт дархлаажуулалтын арга хэмжээг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.
4. Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгах нь:
  - 4.1. Дархлаажуулалтын 10 хоногийн үеэр 6 сартайгаас 6 хүртэлх насны хүүхдийг улаанбурханы эсрэг вакцинаар 1 удаа нэмэлтээр дархлаажуулах;
  - 4.2. Заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон болон алслагдсан сум, дүүрэг, баг, хорооны зорилтот бүлгийн хүүхдийг бүртгэн уг 10 хоногийн үеэр нэмэлтээр болон нөхөн дархлаажуулах.
5. Дархлаажуулалтын талаар олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах арга хэмжээг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, спортын дэд сайд /Д.Атармаа/-д даалгасугай.



САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

080628

Эрүүл мэнд спортын сайдын  
2015 оны 05 сарын 08 өдрийн  
18 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНААР НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Атармаа, Эрүүл мэнд, спортын дэд сайд

Нарийн бичгийн дарга:

Г.Сүрэнханд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дэд захирал

Зөвлөх:

П.Нямдаваа, Халдварт өвчин, нян судлалын ерөнхий мэргэжилтэн, Академич, АШУ-ны доктор, профессор (зөвшилцсөнөөр)

Гишүүд:

Л.Зэндмаа, Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

П.Оюунцэцэг, Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Нарангэрэл, Халдварт өвчний бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Д.Уранчимэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Б.Ганбат, Нийслэлийн эрүүл мэндийн гзрын орлогч дарга

Ш.Энхтөр, Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн, АУ-ны доктор, клиникийн профессор

Г.Ганбаатар, Анаагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэнд спортын сайдын  
2015 оны 05 сарын 08 өдрийн  
188 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНААР НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

1. Улаанбурхан өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах;
2. Дархлаажуулалтын 10 хоногийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах;
3. Улаанбурхан өвчний өвчлөлийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, нэмэлт дархлаажуулалт түүнд шаардлагатай хүн хүч, зохион байгуулалтын арга хэмжээтэй танилцан арга зүйн зөвлөгөө өгөх;
4. Засгийн газрын 2015 оны 134 дүгээр тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжилт хүрэлцээтэй байгаа эсэх, нэмэлт санхүүжилт шаардлагатай эсэхийг тогтоож, нэмэлт нөөцийг бүрдүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх;
5. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад зөвлөх;
6. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед ажиллах салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг хангаж, зохицуулах;
7. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед хүндрэл, эндэгдлээс сэргийлэх, авах арга хэмжээний талаар шаардлагатай үед мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтран ажиллах, арга зүйн зөвлөмж өгөх, аймаг, орон нутагт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, баг томилон ажиллуулах;
8. Олон улсын байгууллагаас тусlamж, дэмжлэг авах чиглэлээр уулзалт зохион байгуулж, шийдвэр гаргах;
9. Улаанбурхан өвчний үед эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэжлийн баг ажиллуулах, эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
10. Нэмэлт дархлаажуулалтын явцтай танилцах, үр дүнг хэлэлцэх;
11. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн зөвлөлүүдийг хуралдуулах.

Эрүүл мэнд спортын сайдын  
2015 оны 05 сарын 08 өдрийн  
18 дугаар тушаалын 3 дугаар  
хавсралт

**УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНААР НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллага
Нэг. Вакцины хангалт, түгээлтийн талаар				
1.1	Улаанбурхан өвчний эсрэг вакцин, "A" амин дэм болон дагалдах хэрэгслийг захиалах	2015 оны 3 дугаар сард	ХӨСҮТ, ЭМСЯ	ДЭМБ, НҮБ-ЫН ХС
1.2	Улаанбурхан өвчний эсрэг вакциныг хүлээн авч, хадгалах түгээх үеийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн тогтвортой байдлыг хангах	5 дугаар сарын 1-р долоо хоног	Аймаг, нийслэлийн ЭМГ	ХӨСҮТ
1.3	Улаанбурхан өвчний эсрэг вакциныг батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэх	5 дугаар сарын 4-12-ны дотор	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
Хоёр. Зохион байгуулалтын талаар				
2.1	Сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	5 дугаар сарын 4-6-ны дотор	ХӨСҮТ	ЭМСЯ, ДЭМБ, НҮБ-ЫН ХС
2.2	Аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан халдварт судлагч эмч нарт нэмэлт дархлаажуулалтын талаар сургалт зохион байгуулах	5 дугаар сарын 4-8-ны дотор	ХӨСҮТ	ЭМСЯ, ДЭМБ, НҮБ-ЫН ХС
2.3	Сум, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах	5 дугаар сарын 9-14-ны дотор	Аймаг, нийслэлийн ЭМГ	ХӨСҮТ
2.4	Улаанбурханы нэмэлт дархлаажуулалтад хамрагдах 6 сартайгаас 6 хүртэлх насны хүүхдийн шинэчилсэн бүртгэл, судалгаа гаргах	5 дугаар сарын 1-ны дотор	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
2.5	Сонгогдсон газруудад шинэчилсэн бүртгэл, судалгаанд дэмжлэгт хяналт хийх	5 дугаар сарын 8-11-ны дотор	ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	ЭМСЯ
2.6	Дархлаажуулалтаас хоцрох магадлалтай эрсдэлт бүлгийн хүн амын судалгаа, зураглал гаргах	5 дугаар сарын 10-ны дотор	Аймаг, нийслэлийн ЭМГ	ХӨСҮТ
2.7	Дархлаажуулалтын 10 хоногийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулах	5 дугаар сарын 15-ны өдөр	ЭМСЯ, ХӨСҮТ	ДЭМБ, НҮБ-ЫН ХС, Аймаг, нийслэлийн ЭМГ

**Гурав. Дархлаажуулах үйл ажиллагааны талаар**

3.1	6 сартайгаас 6 хүртэлх насын хүүхдийг улаанбурханы эсрэг вакцинаар дархлаажуулах, “А” амин дэмээр витаминжуулах арга хэмжээг зохион байгуулах	5 дугаар сарын 15-25-ны дотор	ЭМСЯ, ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	ДЭМБ, НҮБ-ын ХС
3.2	Сум баг, алслагдсан цэгүүдэд явуулын дархлаажуулалтыг багийг ажиллуулах	5 дугаар сарын 15-25-ны дотор	ЭМСЯ, ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	ДЭМБ, НҮБ-ын ХС
3.3	Нэмэлт дархлаажуулалтын хамралт болон шаардлагатай мэдээллийг өдөр бүр авч нэгтгэх	5 дугаар сарын 15-25-ны дотор	ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	ЭМСЯ
3.5	Нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх	5 дугаар сарын 15-25-ны дотор	ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	ДЭМБ, НҮБ-ын ХС,
3.6	Дархлаажуулалтын хамралтад үнэлгээ хийх	5 дугаар сарын 25-30-ны дотор	ХӨСҮТ	ЭМСЯ, ДЭМБ, НҮБ-ын ХС
3.7	Нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааны тайланг нэгтгэх	6 дугаар сарын 10-ны дотор	ХӨСҮТ, Аймаг нийслэлийн ЭМГ	ЭМСЯ, ДЭМБ, НҮБ-ын ХС

**Дөрөв. Мэдээлэл, сурталчилгааны талаар**

4.1	Дархлаажуулалтын талаар олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах	5 дугаар сарын 15-25-ны дотор	ЭМХТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	ЭМСЯ, ДЭМБ, НҮБ-ын ХС
4.2	Нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагаанд оролцох сайн дурын идэвхтэнг бэлтгэх	5 дугаар сарын 15-25-ны дотор	Аймаг, нийслэлийн ЭМГ	ДЭМБ, НҮБ-ын ХС
4.3	Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдад зориулсан зурагт хуудас, эцэг эхчүүдэд зориулсан санамж хэвлүүлж тараах	5 дугаар сарын 10-ны дотор	ЭМХТ, ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	ДЭМБ, НҮБ-ын ХС
4.4	Нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах, бичил төлөвлөгөө боловсруулах, хяналт хийх эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага боловсруулж хэвлүүлэх, тараах	5 дугаар сарын 10-ны дотор	ХӨСҮТ	ДЭМБ, НҮБ-ын ХС
4.5	Дархлаажуулалтын 10 хоногийн мэдээллийг үүрэн холбооны хэрэглэгчдэд мессежээр илгээх	5 дугаар сарын 15-25-ны дотор	ЭМХТ	ДЭМБ, НҮБ-ын ХС

Эрүүл мэнд спортын сайдын  
2015 оны 05 сарын 08 өдрийн  
18 дугаар тушаалын 4 дүгээр  
хавсралт

УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИН, ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ,  
“А” АМИН ДЭМИЙН ХУВААРЬ

№	Аймгийн нэр	Хүүхдийн тоо	Вакцин (хүн/тун)	0.5 мл тариур	Тариур (5 мл)	Дюулгүй хайрцаг	Маркер	А амин дэм /100.000U	А амин дэм /200.00 IU/
1	Архангай аймгийн ЭМГ	10919	12011	12011	1092	80	22	1127	9404
2	Баян-Өлгий аймгийн ЭМГ	12202	13422	13422	1220	89	24	1484	9842
3	Баянхонгор аймгийн ЭМГ	11257	12383	12383	1126	83	23	1185	9718
4	Булган аймгийн ЭМГ	6286	6915	6915	629	46	13	508	5849
5	Говь-Алтай аймгийн ЭМГ	6492	7141	7141	649	48	13	638	5639
6	Говьсүмбэр аймгийн ЭМГ	2284	2512	2512	228	17	5	263	1902
7	Дорноговь аймгийн ЭМГ	9304	10234	10234	930	68	19	779	7116
8	Дорнод аймгийн ЭМГ	9231	10154	10154	923	68	18	1069	8214
9	Дархан-Уул аймгийн ЭМГ	10582	11640	11640	1058	78	21	1510	8791
10	Дундговь аймгийн ЭМГ	4816	5298	5298	482	35	10	522	4100
11	Завхан аймгийн ЭМГ	8344	9178	9178	834	61	17	870	7201
12	Өвөрхангай аймгийн ЭМГ	13644	15008	15008	1364	100	27	1421	11610
13	Өмнөговь аймгийн ЭМГ	8930	9823	9823	893	65	18	813	6720

14	Орхон аймгийн ЭМГ	9928	10921	10921	993	73	20	1530	8569
15	Сүхбаатар аймгийн ЭМГ	7124	7836	7836	712	52	14	728	6250
16	Сэлэнгэ аймгийн ЭМГ	11493	12642	12642	1149	84	23	1063	10314
17	Төв аймгийн ЭМГ	10071	11078	11078	1007	74	20	705	9805
18	Үвс аймгийн ЭМГ	10230	11253	11253	1023	75	20	1149	8621
19	Ховд аймгийн ЭМГ	10670	11737	11737	1067	78	21	1235	8807
20	Хөвсгөл аймгийн ЭМГ	15527	17080	17080	1553	114	31	1784	12930
21	Хэнтий аймгийн ЭМГ	7932	8725	8725	793	58	16	874	6720
22	Нийслэлийн эрүүл мэндийн газар	174705	192176	192176	17471	1281	349	22125	138412
23	ХӨСҮТ-ийн нөөц		4143	4143	313	1654	0	1554	57708
<b>Нийт</b>		371.971	413311	413311	37509	4382	744	44936	364242

Тайлбар:

Вакцины хорогдлын индекс 1.1

Тариурын хорогдлын индексийг 1.05-аар тооцсон болно.

Эрүүл мэнд спортын сайдын  
2015 оны 05. сарын 08 өдрийн  
188 дугаар тушаалын 5 дугаар  
хавсралт

## УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНЫ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

### Найрлага:

Улаанбурхан өвчний эсрэг вакцин нь Эдмонстон Загреб штаммын идэвхгүйжүүлсэн амьд вирусыг агуулсан, хөлдөөж хатаасан, найруулах уусгагч шингэн дагалдсан байна.

### Үйлчилгээ:

Улаанбурхан өвчнөөс сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

### Хэрэглэх арга:

Ариун зүү, тариур хэрэглэн уусгагч шингэнээр вакциныг найруулна. Вакциныг зөөлөн сэгсрэхэд нунтаг бодис хялбархан задарч уусна. Вакциныг найруулахын өмнө вакцин болон түүний уусгагч шингэнд гадны ямар нэг биет байгаа эсэхийг заавал шалгана. Хэрэв гадны ямар нэг зүйлс байвал вакцин буюу уусгагч шингэнийг хэрэглэж болохгүй.

Вакциныг найруулснаас хойш 6 цагийн дотор хэрэглэнэ. Вакциныг 0.5 мл-ээр гарын бугалганы дээд хэсгийн арьсан дор гүн тарина.

### Хариу урвал:

Вакцин тариулсан хүүхдийн 5-6 хувьд бага зэрэг халуурах, 1-2 хувьд тууралт гарч болох бөгөөд ховор тохиолдолд хамар залгиурын үрэвслийн шинж гарч болно.

### Эсрэг заалт:

Дараах тохиолдолд вакцин тарьж болохгүй. Үүнд:

1. Өндөр халуунтай болон цочмог халдварт өвчний үед;
2. Үг вакцины ямар нэгэн бодист харшилтай;
3. Өмнөх дархлаажуулалтад харшлын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд;
4. Цусны системийн өвчинүүдийн үед;
5. Бөөрний дутагдалтай өвчтөнд;
6. Энэгшлээ алдсан зүрхний эмгэгүүдийн үед;
7. Туяа эмчилгээний үед дархлаа буурсан, кортикостеройд болон цитостатик эм хэрэглэж байгаа өвчтөнд;
8. Төв мэдрэлийн системийн эмгэгтэй өвчтөнд;
9. Цус сэлбүүлснээс хойш 3 сарын дотор;
10. Жирэмсэн эхэд.

### Хадгалах:

Хөлдөөж хатаасан вакциныг +2-+8 хэмд хадгална. Уусгагч шингэнийг хөлдөөж, тасалгааны хэмд хадгалж болохгүй, нарны гэрлээс хол байлгана.

### Савлалт:

10 хүн тунгаар савлагдсан, уусгагч шингэн тусдаа дагалдана.

**Үйлдвэрлэгч:** Энэтхэг улс, Серум институт

Эрүүл мэнд спортын сайдын  
2015 оны 05. сарын 08. өдрийн  
188 дугаар тушаалын 6 дугаар  
хавсралт

МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛЫН ХУВААРЬ

№	Аймгийн нэр	Санамж (ширхэг)	Зурагт хуудас (ширхэг)		
			Эмнэлгийн ажилтны	Сорьц цуглуулах	Хүн амд
1	Архангай аймгийн ЭМГ	2300	23	23	100
2	Баян-Өлгий аймгийн ЭМГ	2300	16	16	100
3	Баянхонгор аймгийн ЭМГ	2300	25	25	100
4	Булган аймгийн ЭМГ	2300	18	18	100
5	Говь-Алтай аймгийн ЭМГ	2300	20	20	100
6	Говьсүмбэр аймгийн ЭМГ	1500	4	4	50
7	Дархан-Уул аймгийн ЭМГ	2300	8	8	100
8	Дорнговь аймгийн ЭМГ	2300	17	17	100
9	Дорнод аймгийн ЭМГ	2300	16	16	100
10	Дундговь аймгийн ЭМГ	2300	17	17	100
11	Завхан аймгийн ЭМГ	2300	26	26	100
12	Орхон аймгийн ЭМГ	2300	13	13	100
13	Өвөрхангай аймгийн ЭМГ	2300	24	24	100
14	Өмнөговь аймгийн ЭМГ	2300	17	17	100
15	Сүхбаатар аймгийн ЭМГ	2300	15	15	100
16	Сэлэнгэ аймгийн ЭМГ	2300	23	23	100
17	Төв аймгийн ЭМГ	2300	28	28	100
18	Увс аймгийн ЭМГ	2300	22	22	100
19	Ховд аймгийн ЭМГ	2300	22	22	100
20	Хөвсгөл аймгийн ЭМГ	2300	28	28	100
21	Хэнтий аймгийн ЭМГ	2300	20	20	100
22	Нийслэлийн эрүүл мэндийн газар	22500	198	198	950
<b>Нийт</b>		<b>70000</b>	<b>600</b>	<b>600</b>	<b>3000</b>